

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	23
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/226
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус Улсын хүүхэлдэйн театрт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын захирлын үүрэг гүйцэтгэгч М.Отгончимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр 2-ны өдрөөс, 2019 оны 2 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сүлд-Аудит ХХК-ийн аудитор П.Наранцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын хүүхэлдэйн театр 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улсын хүүхэлдэйн театрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Улсын хүүхэлдэйн театр нь төрөөс баримтлах соёлын бодлогын хүрээнд бүх нийтэд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий монгол улсын төрийн өмчит соёл урлагын төв байгууллага юм гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Улсын хүүхэлдэйн театр нь 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёл урлагийн үйл ажиллагаа

Улсын хүүхэлдэйн театрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Улсын хүүхэлдэйн театрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Монгол улсын үндсэн хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр санхүүгийн тайланд орлого авч бүртгэсэн байгаа боловч мөрдөөгүй, аудитын явцад ирүүлээгүй тул бодлогын баримт бичигтэй танилцаагүй болно.

Улсын хүүхэлдэйн театрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын хүүхэлдэйн театр санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Accolous” програм хангамж ашигладаг байна.

Улсын хүүхэлдэйн театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Улсын хүүхэлдэйн театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн аудитын 5 чиглэлд 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь санхүүжилтийг зөв зохистой хууль дүрэм журам, зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгахтай холбоотой юм.

Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны нийт зардал 440,259.6 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 880.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь тус байгууллагын эрсдэлийн түвшин дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 6 асуудлыг аудитын явцад менежментийн захидалд зөвлөмжөөр хүргүүллээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	4,442.4	
	Дүн	6	4,442.4	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад үнэт цаасны бүртгэлийг гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улсын хүүхэлдэйн театрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 373,205.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 372,984.6 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардал болох 221.3 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Улсын хүүхэлдэйн театр Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Үүнд:

Тайланд онд Улсын хүүхэлдэйн театрын хувьд <http://www.shilendans.gov.mn/> цахим санд 148 төрлийн мэдээллийг жил, улирал, сарын давтамжтайгаар оруулахаас 136 мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж, 12 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай биелэгдсэн байна гэж үзэж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улсын хүүхэлдэйн театрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан асуудлууд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаарх асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж санхүүгийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөөгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Энэ нь үнэн зөв, бодитой оршин байх, хэмжилт, үнэлгээ батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь “...Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөх...” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2019 оны үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

3.2 Үнэт цаасны бүртгэлийн талаарх асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бүртгэлд тусгагдсан 2,818.9 мянган төгрөгийн өртөг бүхий тоглолтын билет /үнэт цаас/-ыг жилийн эцэст тоолж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд хөрөнгө дутагдах, ашиглалт шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх “..Хөрөнгө, өр төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ..” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтыг удирдлага болгон ажиллана.

3.3 Дансны авлагын талаарх асуудал

3.3.1 Илрүүлэлт:

2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар Нийгмийн даатгалын байгууллагаас 107.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэйгээр харилцан тооцоо нийлж баталгаажуулсан байгааг дахин тооцоолол хийж шалгахад 90.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байхад 17.1 мянган төгрөгийн зөрүүтэй баталгаажуулсан байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид тооцооллыг зөв хийж үлдэгдлээ баталгаажуулж байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зохих журмын дагуу тооцоолол хийн засаж ажиллана.

3.4 Байгууллагын ойн арга хэмжээний талаарх асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Улсын хүүхэлдэйн театр 70 жилийн ойгоо 2018 оны 11 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд арга хэмжээний зардлын нэгдсэн төсөв гаргаж холбогдох дээд байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

3.4.2 Эрсдэл:

Хууль дүрэм хэрэгжихгүй байх эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох дээд шатны байгууллагаас зардлын төсөв төлөвлөгөөгөө батлуулж төсвийн дагуу зарцуулах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйл ажиллагаандаа анхаарч ажиллана.

3.5 Цалингийн зардлын талаарх асуудал

3.5.1 Илрүүлэлт:

2018 онд нэр бүхий 5 ажилтанд байгууллагын захирлын үүрэг гүйцэтгэгчийн тушаалаар 1,057.7 мянган төгрөгийн цалинтай чөлөө олгосон байгаа нь баталгаажуулах нотлох баримт хангалтгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, орлого зардлын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Цалинтай чөлөө олгоход тухайн ажилтнуудын чөлөөтэй байх хугацааны эмнэлгийн магадалгаа болон бусад шалтгааны үндэслэлийг тогтоож олгож байх

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тайлан мэдээг зөв гарган холбогдох баримтыг бүрдүүлэн ажиллана.

3.6 Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 2,386.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээ /илтгэгчдийн урамшуулал/ худалдан авч хувь хүмүүст гэрээт ажлын хөлс олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй 548.7 мянган төгрөг олгосон.

3.6.2 Эрсдэл:

Нийгмийн даатгалын хуулийг хэрэгжүүлэхгүй байх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээгээр ажил гүйцэтгэсэн хүмүүст олгосон ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгах. Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.2 болон Иргэний хуулийн 343,359 дүгээр заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 4 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,076,003.92	15,844,846.28
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	107,146.36
35	БАРАА МАТЕРИАЛ	4,076,003.92	15,737,699.92
351	Түүхий эд материал	2,747,003.92	2,818,988.92
35110	Тусгай зориулалттай материал	2,747,003.92	2,818,988.92
354	Хангамжийн материал	1,329,000.00	12,918,711.00
35470	Бусад хангамжийн материал	1,329,000.00	12,918,711.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	63,716,858.17	52,826,270.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	63,716,858.17	52,826,270.58
392	Биет хөрөнгө	63,536,858.17	52,826,270.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,873,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,873,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	686,684,186.00	676,375,997.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(671,880,327.38)	(665,163,638.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	94,303,603.00	50,249,385.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,746,047.03)	(40,680,371.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,170,668.00	63,476,508.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(29,501,882.42)	(33,684,547.41)
39217	Ном	1,506,658.00	2,252,938.00
393	Биет бус хөрөнгө	180,000.00	135,000.00
39301	Програм хангамж	1,170,000.00	1,170,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(990,000.00)	(1,035,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	67,792,862.09	68,806,116.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	67,792,862.09	68,806,116.86
51	Засгийн газрын хувь оролцоо	67,792,862.09	68,806,116.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	810,567,666.94	810,567,666.94
51101	Өмч: - төрийн	810,567,666.94	810,567,666.94
512	Хуримтлагдсан үр дүн	(747,997,635.85)	(743,380,131.08)
51210	Өмнөх үеийн үр дүн	(751,712,761.91)	(744,393,385.85)
51220	Тайлант үеийн үр дүн	3,715,126.06	1,013,254.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,222,831.00	1,618,581.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	67,792,862.09	68,806,116.86

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	357,906,000.00	441,272,895.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,519,500.00	57,074,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	61,519,500.00	57,074,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,519,500.00	57,074,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,904,500.00	55,824,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,615,000.00	1,250,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	296,386,500.00	384,198,895.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,386,500.00	323,205,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	291,386,500.00	323,205,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	60,992,995.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	57,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	3,892,995.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	354,190,873.94	440,259,640.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	338,155,702.73	440,259,640.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	338,155,702.73	431,214,333.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,883,320.00	240,344,799.82
210101	Үндсэн цалин	211,482,720.00	197,621,990.31
210102	Нэмэгдэл	-	21,810,489.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,400,600.00	20,912,320.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,868,789.19	28,512,847.48
210201	Тэтгэврийн даатгал	17,140,276.19	21,805,735.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,824,353.00	1,680,832.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,278,296.00	1,254,632.78
210204	Ажилгүйдлийн даатгал	436,427.00	352,396.34
210205	Эрүүл мэндийн даатгал	4,189,437.00	3,419,250.37
2104	Хангамж, бараа материалын зардал	5,564,599.60	9,979,574.00
210401	Бичиг хэрэг	839,700.00	2,281,110.00
210402	Тээвэр, шатахуун	2,005,000.00	3,305,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	818,219.60	1,548,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,901,680.00	2,845,464.00
2105	Нормативт зардал	1,763,600.00	10,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,763,600.00	10,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,299,330.00	17,547,500.00
210604	Урсгал засвар	11,617,730.00	17,547,500.00
2107	Томиллолт, зочны зардал	6,340,200.00	9,420,200.00
210701	Гадаад албан томиллолт	5,000,000.00	-
210702	Дотоод албан томиллолт	1,340,200.00	9,420,200.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,103,200.38	91,089,965.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,133,300.38	89,018,365.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	821,500.00	831,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,332,663.56	34,489,447.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,506,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,068,540.00	1,374,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,264,123.56	17,608,747.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,035,171.21	9,045,306.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,975,600.00	3,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,675,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,300,000.00	3,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,059,571.21	6,045,306.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,059,571.21	6,045,306.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	3,715,126.06	1,013,254.77
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН	3,715,126.06	1,013,254.77

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	348,126,257.00	440,022,895.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,249,435.00	55,824,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,249,435.00	55,824,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,249,435.00	55,824,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,904,500.00	55,824,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,344,935.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,876,822.00	384,198,895.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,386,500.00	323,205,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	291,386,500.00	323,205,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	60,992,995.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	57,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	3,892,995.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,490,322.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,490,322.00	-
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	340,999,137.00	433,169,735.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	340,999,137.00	433,169,735.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,963,965.79	424,124,428.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,373,641.96	240,344,799.82
210101	Үндсэн цалин	212,973,041.96	208,617,499.82
210102	Нэмэгдэл	-	8,291,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,400,600.00	23,436,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,868,789.23	28,619,993.84
210201	Тэтгэврийн даатгал	21,801,095.03	21,804,735.17
210202	Тэтгэмжийн даатгал	849,226.20	1,680,832.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,065,076.00	1,361,779.14
210204	Ажилгүйдлийн даатгал	204,020.00	352,396.34
210205	Эрүүл мэндийн даатгал	1,949,372.00	3,420,250.37
2104	Хангамж, бараа материалын зардал	5,564,599.60	9,521,720.00
210401	Бичиг хэрэг	839,700.00	1,380,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,005,000.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	818,219.60	1,548,000.00
210404	Ном, хэвлэл	-	93,720.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,901,680.00	3,000,000.00
2105	Нормативт зардал	1,763,600.00	3,525,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,763,600.00	3,525,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,299,330.00	18,433,895.00
210604	Урсгал засвар	11,617,730.00	18,433,895.00
2107	Томилолт, зочны зардал	6,340,200.00	9,240,200.00
210701	Гадаад албан томилолт	5,000,000.00	-

210702	Дотоод албан томилолт	1,340,200.00	9,240,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,340,330.00	97,164,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,370,430.00	95,093,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	821,500.00	831,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,413,475.00	17,274,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,344,935.00	15,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,068,540.00	1,374,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,035,171.21	9,045,306.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,975,600.00	3,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,675,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,300,000.00	3,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,059,571.21	6,045,306.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,059,571.21	6,045,306.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,127,120.00	6,853,160.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,127,120.00	6,853,160.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,127,120.00	6,853,160.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,127,120.00	6,853,160.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,127,120.00	6,853,160.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,127,120.00)	(6,853,160.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	810,567,666.94	5,222,831.00	(751,712,761.91)	64,077,736.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,567,666.94	5,222,831.00	(751,712,761.91)	64,077,736.03
Тайлант үеийн үр дүн			3,715,126.06	3,715,126.06
2017 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	810,567,666.94	5,222,831.00	(747,997,635.85)	67,792,862.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			3,604,250.00	3,604,250.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,567,666.94	5,222,831.00	(744,393,385.85)	71,397,112.09
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		(3,604,250.00)		(3,604,250.00)
Тайлант үеийн үр дүн			1,013,254.77	1,013,254.77
2018 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	810,567,666.94	1,618,581.00	(743,380,131.08)	68,806,116.86

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/Төгрөг/			
ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	373,205,900.00	372,984,593.66	221,306.34	99.9
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	373,205,900.00	372,984,593.66	221,306.34	99.9
Бараа, үйлчилгээний зардал	373,205,900.00	372,984,593.66	221,306.34	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,344,800.00	240,344,799.82	0.18	100.0
Үндсэн цалин	208,617,500.00	208,617,499.82	0.18	100.0
Нэмэгдэл	8,291,300.00	8,291,300.00	-	100.0
Унаа, болон бусад нөхөн олговор	23,436,000.00	23,436,000.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,841,300.00	28,619,993.84	221,306.16	99.2
Тэтгэврийн даатгал	19,384,500.00	21,804,735.17	(2,420,235.17)	112.5
Тэтгэмжийн даатгал	2,364,200.00	1,680,832.82	683,367.18	71.1
ҮОМШӨ ний даатгал	1,891,300.00	1,361,779.14	529,520.86	72.0
Ажилгүйдлийн даатгал	472,800.00	352,396.34	120,403.66	74.5
Эрүүл мэндийн даатгал	4,728,500.00	3,420,250.37	1,308,249.63	72.3
Хангамж, бараа материалын зардал	10,268,000.00	10,268,000.00	-	100.0
Бичиг хэрэг	1,380,000.00	1,380,000.00	-	100.0
Тээвэр (шатахуун)	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,548,000.00	1,548,000.00	-	100.0
Ном, хэвлэл	840,000.00	840,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
Нормативт зардал	3,525,000.00	3,525,000.00	-	100.0
Нормын хувцас зөөлөн эдлэл	3,525,000.00	3,525,000.00	-	100.0
Эд хогшил худалдан авах	17,540,900.00	17,540,900.00	-	100.0
Урсгал засвар	17,540,900.00	17,540,900.00	-	100.0
Томилолт, зочны зардал	9,240,200.00	9,240,200.00	-	100.0
Дотоод албан томилолт	9,240,200.00	9,240,200.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	57,571,600.00	57,571,600.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,500,000.00	55,500,000.00	-	100.0
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	240,000.00	-	100.0
Мэдээллийн технологийн зардал	831,600.00	831,600.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,874,100.00	5,874,100.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	4,500,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,374,100.00	1,374,100.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	373,205,900.00	372,984,593.66	221,306.34	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	323,205,900.00	317,160,593.66	6,045,306.34	98.1
Улсын төсвөөс санхүүжих	323,205,900.00	317,160,593.66	6,045,306.34	98.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,000,000.00	55,824,000.00	(5,824,000.00)	111.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	55,824,000.00	(5,824,000.00)	111.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	31.00	31.00	-	100.0
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.19	Аудитын нэр:	Улсын хүүхэлдэйн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2019/19/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын хүүхэлдэйн театр	Мянган төгрөгөөр
------------------------------	-------------------------------	------------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул агаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 12-нд 15.0 мянган төгрөгөөр данс бүртгэлд бүртгэсэн байгаа боловч санхүүгийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөөгүй, аудитын явцад ирүүлээгүй болно.		Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	М.Отгончимэг, Г.Алтанчимэг
2	Тоглолтын билет /Үнэт цаас/-ийг 2018 оны жилийн эцэст тоолж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Бүртгэлд тусгагдсанаар нийт 2,818.9 мянган төгрөгийн үнэт цаасны үлдэгдэлтэй байна.	2,818.9	Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	М.Отгончимэг, Г.Алтанчимэг
3	2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар НД-н байгууллагаас 107.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэйгээр харилцан тооцоо нийлж баталгаажуулсан байгааг дахин тооцоолол хийж давтан шалгахад 90.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй 17.1 мянган төгрөгийн зөрүүтэй баталгаажуулсан байна.	17.1	Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	М.Отгончимэг, Г.Алтанчимэг
4	Улсын хүүхэлдэйн театр 70 жилийн ойгоо 2018 оны 11 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд арга хэмжээний зардлын нэгдсэн төсөв гаргаж холбогдох дээд байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.		Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	М.Отгончимэг, Г.Алтанчимэг
5	2018 онд нэр бүхий 5 ажилтанд байгууллагын захирлын үүрэг гүйцэтгэгчийн тушаалаар 1,057.7 мянган төгрөгийн цалинтай чөлөө олгосон байгаа нь баталгаажуулах нотлох баримт хангалтгүй байна.	1,057.7	Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	М.Отгончимэг, Г.Алтанчимэг
6	Тайлант хугацаанд 2,386.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээ /илтгэгчдийн урамшуулал/ худалдан авсан бөгөөд НДШ суутгаагүй төсөвт төлөөгүй 548.7 мянган төгрөг байна.	548.7	Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	М.Отгончимэг, Г.Алтанчимэг
Дүн		4,442.4			